

ГАРЧИГ

1–3	Бодлогын нийтлэл
4–6	Зохицуулалтын мэдээ
7–9	Байр суурь
10	Тайлбар зөвлөмж
11–12	Тогтвортой санхүүжилт
13–14	Компанийн засаглал, комплайнс
15	Финтек ба регтек
16–23	Судлаачийн индэр
24–25	Инсуртек гэж юу вэ?
26–27	Олон улсын зах зээлийн мэдээ
28	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ БАТАЛЛАА



Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)–уудын дийлэнх нь өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой

хэдий ч дотоод, гадаад банк санхүүгийн байгууллага болон төсөл хөтөлбөрөөс зээл авах, итгэлцлийн үйлчилгээ болон өрийн бичиг гаргах замаар бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлж тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаагаа санхүүжүүлэх боломжтой байдаг. ББСБ–ууд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан 9 төрлийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой байдаг бөгөөд үүний нэг нь тус хуулийн 7.1.8–д заасан итгэлцлийн үйлчилгээ юм. Итгэлцлийн үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр ББСБ болон банк эрхлэх боломжтой.

Итгэлцлийн үйлчилгээг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.7–д “итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/–ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг” ойлгоно гэж тодорхойлсон байдаг. Манай улсад итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ–уудын хувьд ихэвчлэн банкны хадгаламжтай төстэй санхүүгийн бүтээгдэхүүн болох мөнгөн итгэлцлийн үйлчилгээг олон нийтэд санал болгож байна.

Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй ББСБ–уудын эрх зүйн орчныг сайжруулах төслийн хүрээнд манайтай төстэй итгэлцлийн үйлчилгээ явуулж байгаа улсуудын эрх зүйн орчны судалгааг төслийн зөвлөхүүд ирүүлсэн.

Судалгаанд дурдсанаар “Итгэлцэл” гэдэг ойлголт эртний Ромд анх үүссэн ба тус улсад итгэлцэлд суурилан хөрөнгийн захиран зарцуулалтыг өөр талд итгэн хариуцуулдаг байжээ. Харин сонгодог итгэлцлийн үйлчилгээг Англи Улсад XII–XIII зуунд үүссэн гэж үздэг байна. Европын орнуудад хөгжсөн итгэлцлийн үйлчилгээ нь үе дамжиж ирсэн ихээхэн хэмжээний хөрөнгийг удирдах чиглэл рүү хөгжсөн байдаг бол Зүүн Азийн улсууд тэр дундаа Япон, Солонгос, Хятад, Сингапур, Тайван улсуудад хөгжсөн итгэлцэл нь актив хөрөнгө дундаа мөнгөн хөрөнгийг удирдах чиглэл рүү буюу банкны хадгаламжтай төстэй, өрсөлдөхүйц санхүүгийн бүтээгдэхүүн олон нийтэд санал болгож байна.



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

НИЙГМИЙН ШУДАРГА ЁС

Нийгмийн шударга ёс гэдэг бол эрх зүйн хэм хэмжээ хэрэглэхийн оронд нийгмийн бүх салбарт шударга ёс бий болгох, тэгш байдлыг хангах гэсэн хийсвэр ухагдахууныг илэрхийлсэн үзэл баримтлал юм. Энэ нь орлого нэмэгдэх тутам өсөх татвар, орлого дахин хуваарилалт, тэгш боломж ба тэгш үр дүн хэмээн хөгжлийн эдийн засагчдын нэрлэдэг тэнцвэртэй бодлого явуулах замаар эдийн засгийн тэгш байдлыг нэмэгдүүлэх зорилгыг илэрхийлдэг. Нийгмийн шударга ёсны үзэл баримтлалыг заримдаа шударга нийгэм бий болгоход чиглэсэн хөдөлгөөнийг тодорхойлоход хэрэглэдэг. Энэ агуулгаар нийгмийн шударга ёс хүний эрх, тэгш байдлын үзэл баримтлал дээр тулгуурладаг.



SOCIAL JUSTICE

Social justice is the concept in which a subjective notion of justice and/or equality is achieved in every aspect of society, rather than the administration of law. It involves a greater degree of economic egalitarianism through progressive taxation, income redistribution, policies aimed toward achieving that which developmental economists refer to as equality of opportunity and equality of outcome. Social justice is also a concept that some use to describe the movement towards a socially just world. In this context, social justice is based on the concepts of human rights and equality.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БРОКЕР, АГЕНТЫГ “ҮНДЭСНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТ”-Д ХАМРУУЛЛАА

Үргэлжлэл 1-р нүүрт

Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд итгэлцлийн үйлчилгээ нь тусгай зөвшөөрөлтэй, эрх зүйн иж бүрэн зохицуулалттай санхүүгийн байгууллагуудын санал болгодог санхүүгийн бүтээгдэхүүн юм. Эдгээр улсууд нь итгэлцлийн үйлчилгээний тухай бие даасан хуультай, зохицуулагч байгууллагаас баталсан нарийвчлан зохицуулсан журмын хүрээнд зөвшөөрлийг олгож, хяналтыг хэрэгжүүлж байна.

Нийтлэг ажиглагдсан зохицуулалтын хувьд тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн байгууллага болон хүний нөөцөд нь нарийвчилсан, өндөр шаардлагыг тавьдаг ба мөн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх, мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлохтой холбоотой шаардлагуудыг нэлээд тавьдаг байна.

Санхүүгийн тайлан мэдээний хувьд итгэлцлээр татан төвлөрүүлсэн хөрөнгөөр ямар үйл ажиллагааг санхүүжүүлж байгааг тодорхой тайлагнахыг шаарддаг байна. Манай улсын ББСБ-уудын хувьд итгэлцлээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг ихэвчлэн тусгай зөвшөөрөлтэй зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Манай улсын хууль, эрх зүйн орчны хувьд итгэлцлийн үйлчилгээг Банк бус

санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар тодорхойлсон байдаг бол хөрөнгө итгэмжлэх гэрээний талаар Иргэний хуулийн 406 дугаар зүйлд зааж өгсөн байдаг.

Итгэлцлийн үйлчилгээ нь бусдын хөрөнгийг тодорхой хугацаанд удирдах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаа байдгаараа онцлогтой. Иймд Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээдийн эрхлэх итгэлцлийн үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 434 дүгээр тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг баталсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 136 дугаар тогтоолоор Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлж, Улаанбаатар хотод 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөг, бусад аймаг сумдад 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөг байхаар тогтоож, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан байсан ББСБ-уудыг 2026 оныг хүртэлх хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэх

хуваарийг баталсан. Журмын хязгаарлалтын хувьд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.1-т “итгэлцлийн үйлчилгээний өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 80 хувиас хэтрэхгүй” байхаар зохицуулсан байдаг.

ББСБ-ын салбарын оролцогчдын тоо 2022 оны мөн үеэс 0.9 хувиар буурч 522-т хүрсэн хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйлчилгээний нэр төрөл, бүтээгдэхүүн хүргэлтийн сувгаа тэлж, олон төрлийн үйлчилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр санхүүгийн үйлчилгээг шаардлагатай зорилтот бүлгүүдэд хүргэх замаар бизнесийн болон өрхийн эдийн засгийг тэтгэж, харилцагч, үйлчлүүлэгчид нэг дороос олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах чанарын шилжилт хийгдэж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 71 ББСБ 6,797 итгэмжлэгчээс 449.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 49.6 хувь буюу 149.0 тэрбум төгрөгөөр өсөж, өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг үзүүллээ.

Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд 1.6 дахин, өмнөх оны мөн үеэс 23 ББСБ-аар буюу 38.9 хувиар, итгэмжлэгчдийн тоо 2020 оны мөн үеэс 81.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 1,025-аар буюу 17.7 хувиар тус тус өслөө.

Үүнийг газар зүйн байршлаар ангилбал Улаанбаатар хотын 69 ББСБ 6,789 итгэмжлэгчээс 447.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг бусдаас татсан бол хөдөө орон нутгийн 2 ББСБ 8 итгэмжлэгчээс 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Төгрөгөөр байршуулсан итгэлцлийн өглөг өмнөх оны мөн үеэс 111.9 тэрбум төгрөгөөр буюу 42.4 хувиар, 2019 оны мөн үеэс 307.4 тэрбум төгрөгөөр буюу 4.5 дахин, валютаар байршуулсан итгэлцлийн өглөг өмнөх оны мөн үеэс 37.2 тэрбум төгрөгөөр буюу 101.3 хувиар, 2019 оны мөн үеэс 57.9 тэрбум төгрөгөөр буюу 3.6 дахин өслөө.

Арилжааны банкнууд 2023 оны эхнээс харилцах дансанд хүү олгож, хадгаламжийн хүүгийн хэмжээг дунджаар сарын 0.13 пунктээр өсгөсөнтэй холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж

байгууллагаас ББСБ-д байршуулсан итгэлцлээр татсан хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеийн өсөлтөөс 18.1 хувиар саарсан бол төгрөгийн валюттай харьцах ханш суларснаас үүдэн валютаар татан төвлөрүүлэх итгэлцлийн үйлчилгээний өр 6.1 хувиар өсөж, цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар итгэлцлээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн жигнэсэн дундаж үр шим жилийн 16.6 хувь байгаа нь арилжааны банкуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 10.6 хувиас 6.0 пунктээр өндөр байна.

Иймд мөнгөний бодлогын хүү, инфляцын тогтворгүй орчин, төгрөгийн ханшийн сулралт, зах зээлийн эрсдэл, арилжааны банкууд хадгаламжийн хүүгийн өсөлт нь итгэлцлийн үр шимийг тогтооход голлон нөлөөлж, улмаар эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлсээр байна.

Арилжааны банкуудын санхүүгийн байгууллагуудад шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.5 хувь байгаа нь ББСБ-аас авсан зээлийн эх үүсвэртэй харьцуулахад хүүгийн марж 1.8 хувиар бага байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр сарын 0.4–3.3 хувь буюу дунджаар 1.4 хувийн үр шим амлаж, итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татаж байгаа нь зээл олголт, зээлийн тасалдал үүсгэхгүй байх үндсэн нөхцөл болж байгаа хэдий ч энэ нь хүүгийн зардлыг нэмэгдүүлж байна.

Цаашид, шинээр баталсан журмын хүрээнд итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд журам батлагдахаас өмнө итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлөө авсан байсан ББСБ-уудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг заасан хугацаанд, тогтоосон хэмжээнд хүргэх, журам батлагдсанаас хойших хугацаанд шинээр байгуулах хөрөнгө итгэмжлэх гэрээг журмын шаардлагад нийцүүлэх мөн журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай. Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд журам тогтоолын биелэлтэд хяналт тавин ажиллана.


ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭВ



Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгалын холбоо, даатгалын компаниуд болон зуучлагч банкуудын төлөөллүүд энэ сарын 17-ны өдөр Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүний үр дүн, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэ үеэр малын индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий “Үндэсний давхар даатгал” ХК-аас дээрх хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулж, малын индексжүүлсэн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх болон тулгамдаж буй бусад асуудлын талаар оролцогчдын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв.


Малын индексжүүлсэн даатгалын үр дүн 2012-2023



Малын индексжүүлсэн даатгал нь малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдийн мал сүргийг ган, зуд зэрэг байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлийн улмаас үүсч болзошгүй гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилготой манай улсын мал аж ахуй, нийгэм эдийн засагт чухал ач холбогдол бүхий даатгалын бүтээгдэхүүн юм. Засгийн газар, Дэлхийн банктэй хамтран Малын индексжүүлсэн

даатгалын төслийг 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн бол Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 онд батлагдсан билээ.

2022 ОНЫ НӨХӨН ТӨЛБӨР /АЙМГААР/



Өнөөдрийн байдлаар малын индексжүүлсэн даатгалд нийт 35,704 малчин өрх 7 сая гаруй малаа даатгуулж, 4.96 тэрбум төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн бол 2022–2023 онд тохиосон зудын улмаас малчдад учирсан хохиролд даатгалын компаниуд нийт 4.17 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон үзүүлэлттэй байна.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО



Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг шударга, нээлттэй, ил тод зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтох боломжийг бүрдүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор хангах замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж, улс



орны эдийн засгийн өсөлтөд салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор УИХ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, өнгөрсөн 6-р сарын 30-ны өдрөөс мөрдөж эхлээд байна. Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хороо Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан холбогдох журмуудыг боловсруулж, мөрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар хоёр компанид уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоод байна.

Үүнтэй холбогдуулж уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа. Энэ үеэр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтэй этгээдүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зохицуулалтын талаарх ерөнхий ойлголт, брокерын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүсэлт гаргахад анхаарах зүйлс, арилжаанд оролцох үйл явц, системийн танилцуулгыг хийх зэрэг мэдлэгийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай хамтран олгосон юм.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн анхны хуралдаан энэ сарын 16-ны өдөр боллоо. Хуралдаанаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, түүний хэрэгжилт, холбогдох журмууд болон хуулиар заасан чиг үүргийн хүрээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох хүүгийн дээд хэмжээг тогтоохтой холбогдуулж хийсэн зээлийн хүүгийн судалгаа, зээлийн барьцаа, батлан даалтын гэрээний ерөнхий загварын төсөл, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалын ерөнхий загварын төслийн талаар танилцуулж, санал солилцлоо.

УИХ-аас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг өнгөрсөн оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталж,

энэ оны 03-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Үүнтэй холбогдуулж Санхүүгийн зохицуулах хороо хуулийн хэрэгжилтийг хангуулахаар “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталж улмаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийг байгуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуунаар ахлуулсан



бодлогын зөвлөлд ШӨХТГ, Санхүүгийн зохицуулах хорооны, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, МҮХАҮТ, СЭЗИС, Монголын мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо ГҮТББ, Барьцаалан зээлдүүлэх бизнес эрхлэгчдийн эвсэл холбоо ГҮТББ-ын холбогдох дарга, албан тушаалтнууд гишүүдээр ажиллаж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН АНХААРАЛД

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан журамд арилжаа эрхлэгч нь санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр, борлуулалтын мэдээг сар бүр тайлагнахаар зохицуулсан байсан бол шинэчлэн баталсан журмаар эдгээр тайлан, мэдээг улирал бүрийн эхний сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахаар зохицуулсан. Журамд орсон өөрчлөлттэй холбогдуулан арилжаа эрхлэгчээс ирүүлбэл зохих тайлан, мэдээний хугацааг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг дуустал сунгасан тул тайлан,

мэдээг заасан хугацаанд ирүүлнэ. Дээрх хугацаанд холбогдох тайлан, мэдээг Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаагүй тохиолдолд холбогдох хуульд заасан арга хэмжээ авахыг

мэдэгдэж байна. Мөн тайлан, мэдээний хугацааг цаашид дахин сунгах боломжгүй тул улирал бүр журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж хэвшихийг зөвлөжээ.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ МОД ТАРИХ ХӨДӨЛГӨӨНД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХАМТ ОЛОН ГУРАВ ДАХЬ ЖИЛЭЭ НЭГДЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш гурав дахь жилээ үргэлжилж байна. Жил бүрийн 5 болон 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарласан бөгөөд энэ жилийн хувьд өнгөрсөн амралт /10.07/-ын өдөр тохиосон. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны хамт олон энэхүү хөдөлгөөнд гурав дахь жилээ нэгдэж



цөлжилтөд ихээр өртөөд буй Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохицуулалтын зарим байгууллагын хамтаар мод тарилаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр “Тэрбум мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлснээр зөвхөн Монгол Улс төдийгүй дэлхийн дулаарлын эсрэг олон улсын зорилго зорилтуудад чиглэсэн чухал алхам билээ. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны хамт олон гурав дахь жилээ нэгдэж мод тарихын зэрэгцээ санхүүгийн салбартаа ч ногоон

санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг нь тэлэх ингэснээр байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгоор ажиллаж байна. Ингэхдээ зах зээлд энэ төрлийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, ногоон хөрөнгө оруулалтын оролцоог тэлэх, нээлттэй болгох бодлого боловсруулахад онцгой анхаарч ажиллалаа. Тухайлбал, биржийн болон биржийн бус зах зээл дээр ногоон бонд гаргах эрх зүйн орчныг бүрдүүллээ. Мөн “Байгаль орчин нийгэм, засаглал (БОНЗ), Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг гаргаж, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлагын журамд “ногоон даатгал”-ыг тодорхойлж, даатгалын компаниуд энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах эрхзүйн орчныг мөн бүрдүүлсэн. Түүнчлэн “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой

эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг баталсан бол одоо ногоон зээл, ногоон бонд зэрэг бүтээгдэхүүнүүдэд батлан даалт гаргуулахаар дотоодын болон гадаадын батлан даалтын сангуудтай хамтарч ажиллаж байна. Ингээд салбарын нийт оролцогчдодоо ногоон санхүүжилтийг хөгжүүлэхийн төлөө хамтарч ажиллахын зэрэгцээ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж хамтдаа мод тарихыг уриалж байна” гэсэн юм.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооныхон салбарын байгууллагуудынхаа хамтаар Сонгинохайрхан дүүргийн Баянхошуунд байрлах Бумбатын ам, Ар Гүнтэд байрлах “Инчьеон мөрөөдлийн төгөл”, Минж үржүүлэн нутагшуулах төвд байрлах банк бус санхүүгийн байгууллагуудын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, Баянзүрх дүүргийн Гачуурт тосгон болон Өвөрхангай аймгийн Хархорин суманд тус тус мод тариад байна.

БАЙР СУУРЬ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, САНХҮҮЖИЛТ ТАТАХ БОЛОМЖ

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй ярилцлаа



Сайн байна уу. Юуны өмнө ярилцлагаа хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчинд орсон өөрчлөлт, шинэчлэлүүдийн талаар эхлүүлэе. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа вэ?

Улсын Их Хурлаас өнгөрсөн оны 12 дугаар сард Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан бөгөөд тус хууль энэ оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосны дагуу Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор боловсруулаагүй болон баяжуулсан нүүрс, төмөр болон хайлуур жоншны хүдэр, баяжмалыг арилжаалахаар шийдвэрлэсэн.

Үүнтэй холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 385 дугаар тогтоолоор олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК амжилттай зохион байгуулж байгаа бөгөөд тус биржээс уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэхтэй

холбоотой 11 харилцааг зохицуулсан 7 журмыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулсан ба одоогийн байдлаар нийт 6.2 сая нүүрс болон төмрийн хүдэр, баяжмалыг 2.9 их наяд төгрөгөөр арилжаалаад байна. Түүнчлэн одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу брокерын эрхийг 2 компанид олгоод байна.

Уул уурхайн бүтээгдэхүүн биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлснээр арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу тал бий болсон. Цаашид уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

Өөр бусад журмын зохицуулалтын ямар шинэчлэл байгаа вэ?

Улсын Их Хурлаас өнгөрсөн оны 6 дугаар сард Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, энэ оны 1 дүгээр сард Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг тус тус баталсан. Үүний хүрээнд хөрөнгийн үнэлгээний тухай хуульд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Бизнесийн үнэлгээ хийх журам” болон “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг тус тус баталсан бол Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран холбогдох журмууд болон шаардлагыг энэ оны 8 дугаар сард тус тус батлаад байна. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталснаар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Мөн үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны дүрэм, журам болох “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг баталсан. Энэхүү шинэчилсэн найруулгаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. Үүний сацуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт тавих шаардлагад өөрчлөлт оруулаад байна.

Мөн үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны дүрэм, журам болох “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг баталсан. Энэхүү шинэчилсэн найруулгаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. Үүний сацуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт тавих шаардлагад өөрчлөлт оруулаад байна.

Санхүүгийн зохицуулах хороо Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?

Хөрөнгө оруулагч, аж ахуй нэгж, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын идэвх, сонирхлыг өсгөх, олон нийтэд санал болгон хувьцаа, компанийн бонд гаргахтай холбоотой зардал, өртгийг бууруулах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг энэ оны 5 дугаар сард баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлага, цаг хугацаа, өртгийг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” болон “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Түүнчлэн ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахтай холбоотой холбогдох дүрэм, журмын талаарх ойлголт, мэдээллийг өгөх сургалт, арга хэмжээг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцооноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх,



компанийн нэр хүндээ өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой.

Хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд ихээхэн өсөж, хөгжиж байгаа хэдий ч гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ дутмаг хэвээр байна гэж харж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос ямар арга хэмжээг авч, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгахад гадаад, дотоодын мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагчдын оролцоо нэн чухал бөгөөд тэр дундаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоог бүрдүүлснээр хөрөнгийн зах зээлийн идэвх нэмэгдэж, дотоодын аж ахуйн нэгжүүд шаардлагатай урт хугацааны санхүүжилтээ хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх, жижиг хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын сангуудаар дамжуулан урт хугацааны тогтвортой өгөөж хүртэх, хөрөнгийн дахин хуваарилалт хийгдэж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжиж, компаниуд цар хүрээгээ тэлэн олон улсын зах зээл дээр гарах давуу талтай юм.

Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын хөрөнгийн зах зээл рүү татан нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаа, оролцоог нь дэмжсэн хөрөнгө оруулалтын сангийн багц журмуудыг олон улсын жишигт нийцүүлэн 2022 онд шинэчлэн баталсан. Тодруулбал, биржээр арилжаалдаг хөрөнгө оруулалтын сан буюу олон улсын хөрөнгийн зах зээлд түгээмэл хэрэглэгддэг санхүүгийн хэрэгсэл болох “Exchange traded fund” – ийн зохицуулалтыг тусгаж өгснөөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд хамгийн анхны биржээр арилжаалагддаг санг үүсгэн байгуулах баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо энэ оны 6 дугаар сард бүртгэсэн.

Уг журмын зохицуулалтын үр дүнд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сангууд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх нь нэмэгдсэнээр эрэлт талыг бүрдүүлэгч мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь бэхжихээс гадна нийлүүлэлт талаас шинэ бүтээгдэхүүний тоо өсөж, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ нэмэгдэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо, зах зээлд итгэх итгэл өсөх давуу тал бүрдэж байгаа юм. Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр хамтын хаалттай 2, хамтын

нээлттэй 3 сан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд цаашид ч хамтын сангуудын тоо өсөн хөрөнгийн зах зээл дэх оролцоо нь нэмэгдэнэ гэж харж байна.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах өөр нэгэн арга зам бол татварын бодлогоор дэмжих, татварын таатай эрх зүйн орчныг бий болгох юм. Үүний хүрээнд олон улсын туршлагад үндэслэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар зорьж байна. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын дотоодын хувьцаа, өрийн хэрэгсэл борлуулсны орлогод албан татвар ногдуулахдаа Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн адилаар тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцох зохицуулалтыг тусгаж өгсөн. Тухайлбал одоогийн хуулийн зохицуулалтаар Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч дотоодын үнэт цаасны зах зээлд шууд хөрөнгө оруулан худалдан авсан хувьцаа болон өрийн хэрэгслээ борлуулахад татвар ногдуулах орлогыг нийт дүнгээс тооцдог ялгавартай зохицуулалт үйлчилж байгаа нь цаашид гадаадын хөрөнгө оруулагчдын татахад сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.

Мөн тус хуулийн төслийн хүрээнд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан хувьцаа болон өрийн хэрэгсэл борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр төлөвлөсөн. Эдгээр өөрчлөлтүүд нь манай улсын хөрөнгийн зах зээлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх зэрэг эерэг өөрчлөлтүүдийг авчрах хүлээлттэй байна.

Түүнчлэн гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх хүрээнд нээлттэй компаниудыг гадаадын болон дотоодын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэх, хадгаламжийн бичиг (depository receipt) гаргахад дэмжлэг үзүүлэх, зайны брокерын үйлчилгээг нэвтрүүлэх, хувьцаат компаниудын тайлан, мэдээ, мэдээллийг англи хэл дээр гаргах, түгээх, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг сайжруулах зэрэг чиглэлд олон улсын зохицуулагч байгууллага, холбоо болон санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллахаар зорьж байна.

ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

“ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны нэг төрөл болох итгэлцлийн үйлчилгээ нь бусдын хөрөнгийг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулж тодорхой үр шим хүртэх зорилготой үйлчилгээ юм.

Итгэлцлийн үйлчилгээг үзүүлж буй банк бус санхүүгийн байгууллагын зохистой үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоосон тусгайлсан зохицуулалтыг бий болгох ингэснээрээ итгэлцлийн үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 434 дугаар тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг баталсан бөгөөд тус журамд дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл,
2. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлага,
3. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд баримтлах нөхцөл шаардлага,
4. Хөрөнгө итгэмжлэх гэрээ гэсэн үндсэн 4 бүлэгтэй.

Нийтлэг үндэслэл бүлэгт журмын зорилгыг тодорхойлж, холбогдох ямар хууль журмыг мөрдөхийг зааж өгсөн бол үйл ажиллагаанд тавигдах шаардлага бүлэгт итгэлцлийн үйлчилгээ авах болон авсны дараах шаардлагыг тодорхойлж өгсөн.

Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлага бүлэгт итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй этгээдэд тавих нийтлэг шалгуур үзүүлэлт, шаардлагын талаар заалтуудыг тусгасан бол Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд баримтлах нөхцөл шаардлага бүлэгт үйл ажиллагаа явуулахдаа ямар шаардлага баримталж ажиллахыг зохицуулж өгсөн. Онцлох зохицуулалтыг дурдвал итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нь итгэлцлийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж болох ба ингэхдээ үр шимийн хувь хэмжээг амлахгүй байхаар зохицуулж өгсөн.

Мөн итгэмжлэгдсэн хөрөнгийг даатгалд хамруулах болон гуравдагч этгээдийн баталгаа авах замаар үндсэн дүнг хамгаалж болохоор зохицуулж өгсөн.



Хөрөнгө итгэмжлэх гэрээ бүлэгт гэрээг цаасан болон цахим хэлбэрээр байгуулахыг зөвшөөрсөн бөгөөд гэрээнд заавал тусгах заалтуудыг тодорхойлсон.

Итгэлцлийн үйлчилгээний журмыг батлан хэрэгжүүлснээр эрсдэл даах, санхүү төлбөрийн чадвартай итгэлцлийн үйлчилгээ эрхлэх санхүүгийн мэргэжлийн оролцогч ББСБ-ууд бий болох бол хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хувьд итгэлцлийн үйл ажиллагааны нарийвчилсан ойлгомжтой зохицуулалтын хүрээнд үйлчилгээ авах талуудын эрх, ашгийн зохицуулалтыг тодорхой болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР

Сайн байна уу, Уншигч танд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ сараас эхлэн сэтгүүлийнхээ “Тогтвортой санхүүжилт” буланг “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэр” гэж өөрчлөхөөр боллоо. Учир нь тогтвортой хөгжих үндэс нь дээрх гурван хослолыг тэнцвэртэй хөгжүүлэх байдаг.


Санхүүгийн салбар 2013 оноос эхлэн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгож эхлээд өнөөгийн 10 гаран жилийн түүхээс харахад “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэр”-ийг хангахад олон талын хүчин зүйлс шаардлагатайг илтгэж байна.

Үүний хүрээнд 3 асуултыг асууя. Нэгдүгээрт, иргэд, олон нийт байгаль орчиндоо ээлтэй амьдрах, өөрийнхөө эрхийг хамгаалах чадвар, санхүүгийн хувьд чадавхтай амьдарч сэтгэл хангалуун байна уу? Хоёрдугаарт, аж ахуй нэгжүүд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хэдий ч байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулж чадаж байна уу? Гуравдугаарт, төрийн бодлого оновчтой байж нүдэнд харагдахуйц үр дүнд хүрч байна уу? Үүний доголдол хаана байна вэ?

Хувь хүн миний ажиглалтаар иргэд байгаль орчинд ээлтэй амьдрах амьдралын хэв маягаа өөрчлөх байгаль орчин болон санхүүгийн боловсрол дутмаг. Аж ахуй нэгжүүд байгаль орчинд ээлтэй байх бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээх сэдэл дутмаг. Төрөөс баримталж буй бодлогуудын түгээлтийн суваг оновчтой бус. Үүнээс дүгнэх ерөнхий дүгнэлт “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэр”-ийг хангахад чиглэсэн үйл ажиллагаануудыг зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн суваг маш дутмаг. Түүнчлэн 21 аймагт хүрэх хүртээмж дутмаг.

Иймээс сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаараар уншигч танаас “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэр”-ийг хангахад судлах шаардлагатай зүйлс, шийдэл, боломжуудын талаар саналыг narantuya@frc.mn хаягаар авч, тантай хамтран ажиллах гэж байна.





Манай улсад нүүрлээд буй агаарын бохирдлыг үүсгэж буй гол хүчин зүйлсийн нэг нь гэр хорооллын утаа байдаг. Учир нь Монгол Улсад 941,547 өрх гэр байгаагийн 637,100 буюу 67.7 хувь нь Улаанбаатар хотод, 304,447 буюу 32.3 хувь нь орон нутагт амьдардаг. Түүнчлэн Үндэсний статистикийн хорооны 10 жилд нэг удаа явуулдаг хүн амын тооллогоор нийт өрхийн 76 хувь нь гэр болон байшинд амьдардаг байна.

Хот, хөдөөгийн хөгжил тэнцсэнээр Улаанбаатар дахь хүн амын төвлөрөл буурна. Аймгуудад иргэдийг амьдрах таатай нөхцөл бүрдээгүйн улмаас хот руу шилжин суурьших нүүдэл үргэлжилсээр, харин аймгуудын хөгжил төдийлөн сайн урагшилсангүй.

Тиймээс хэрхэн Япон, АНУ улс шиг Улаанбаатарын түвшинд хүрэх хөгжлийг аймгуудад хүргэх вэ?, Хүртээмжийг ямар сувгаар хүргэх вэ?

Таны санал үнэ цэнтэй байх болно. Баярлалаа.

Эх сурвалж: <https://www.isometrix.com/blog/esg-data-collection/>

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

КОМПЛАЙНСЫН АЖИЛТАНД ШААРДАГДАХ УР ЧАДВАР

Эрчимтэй хувьсан өөрчлөгдөж буй зохицуулалтын орчинд комплайнсын ажилтан ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд тодорхой ур чадварууд шаардагдана.

Эрчимтэй хувьсан өөрчлөгдөж буй зохицуулалтын орчинд комплайнсын ажилтан ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд тодорхой ур чадварууд шаардагдана.

Криптовалют болон блокчэйний зохицуулалтыг нарийвчлан чангатгаж байгаа өнөөгийн нөхцөлд комплайнсын ажилтны үүрэг оролцоо маш чухал бөгөөд тэрээр компани үйл ажиллагаагаа ёс зүйтэй, шударгаар хэрэгжүүлэх, зөрчил үүссэн тохиолдолд түүнийг зохицуулах гэх мэт бизнесийн бүхий л үйл ажиллагаагаа зохицуулалтын хүрээнд байгаа эсэхэд хяналт тавьдаг. Ур чадвар нь техникийн мэдлэг, туршлагаас гадна үлгэр жишээ комплайнсын ажилтныг тодорхойлох чухал үзүүлэлт.

Яагаад гэвэл ур чадвар нь бүхий л салбарт чухал үүрэгтэй ба мэргэшсэн ажилтнууд бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаас эхлээд цаг төлөвлөлт, ашиглалтыг зохицуулах хүртэл бүх асуудлыг шийдвэрлэхэд тусалж байна. Өөрөөр хэлбэл, ур чадвар нь ямар нэгэн тодорхой ажлын байр, салбарын онцлогт тусгайлан

хамаардаггүй ерөнхий шинж чанарууд аж. Ур чадварыг ихэвчлэн өөрийгөө хөгжүүлэх замаар олж авдаг бөгөөд хөрвөх чадвартай.

Дэлхий даяар нүүр тулж буй хууль, тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэй хөл нийцүүлэн алхахын тулд хариуцсан ажлаа зохион байгуулах замаар байгууллагын үйл ажиллагааг харилцан уялдуулахад комплайнсын ажилтан дор дурдсан чадваруудтай байх шаардлагатай.

Зөрчлийг зохицуулах

Комплайнсын ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад гарсан зөрчлийг хэрхэн зохицуулах талаарх мэдлэгтэй байх хэрэгтэй. Учир нь компанийн үйл ажиллагааг шинэ нөхцөл, шаардлагад нийцүүлэх, арга барилаа өөрчлөх нь бүтээлч байдалд саад учруулдаг, ялангуяа крипто орчинд тогтсон дүрэм, журам хөгжил, шинэчлэлд саад учруулдаг гэж зарим нь үздэг.

Комплайнсын ажилтан өөрийн үзэл бодлыг хамгаалж, тайлбарлан таниулах чадвартай байх шаардлагатай ба нөгөө талаас, зохицуулагч этгээдтэй харьцах амаргүй нөхцөл байдалтай тулгарсан үед тэдэнд өөрийн итгэл үнэмшил болон уян хатан байдлыг харуулах хэрэгтэй болдог.



Эрсдэлийн үнэлгээ хийх

Бүхий л салбарт эрсдэлийн үнэлгээ хийх чадвар шаардлагатай. Жишээлбэл, нислэгийн зохицуулагч агаарын хөлгийг аюулгүй газардуулахын тулд нөхцөл байдалд дүн шинжилгээг хийдэгтэй нэгэн адил комплайнсын ажилтан эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай бүх хүчин зүйлийг харгалзан үзэж, компанийн нэрийн өмнөөс чухал шийдвэр гаргахдаа өөртөө итгэлтэй байх явдал юм.

Асуудал шийдэх

Комплайнсын ажилтан асуудлыг шийдвэрлэх чадвартай байхын тулд эхлээд нөхцөл байдлыг тайлбарлах чадамжтай байх ёстой.

Эрх бүхий байгууллагын зохицуулалтыг тэсрэх бөмбөгтэй талбайтай жишиж болно. Өөрөөр хэлбэл, төрийн эрх бүхий болон санхүүгийн байгууллагуудын зохицуулалтын орчин байнга өөрчлөгдөж байна. Тулгамдсан асуудалтай холбоотой сорилтыг зохицуулах чадвар бол комплайнсын сайн ажилтны шинж бөгөөд мэдлэгээ ашиглан нөхцөл байдлыг бүх талаас нь дүгнэснээр хамгийн тохиромжтой зөвлөгөөг компанийн удирдлагад өгдөг байна.

Зүгээр л “тийм” эсвэл “үгүй” гэж хэлэх нь хангалтгүй. Зохицуулалтын орчин нь нарийн мэдлэгийг шаарддаг ба зөрчлөөр дүүрэн. Тэгвэл асуудлыг шийдвэрлэх ур чадвар нь тохиромжтой шийдлийг олж, зохицуулалтын арга хэмжээнээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Холбоо тогтоох Комплайнсыг ихэвчлэн тухайн ажилтны үүрэг гэж үздэгээс улбаалан түүнийг зөрчих асуудал түгээмэл байна. Бизнесийн үйл ажиллагааг тодорхой нөхцөл, шаардлагад нийцүүлэх нь комплайнсын ажилтны цорын ганц зорилго биш бөгөөд маркетинг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан, оролцогч талуудтай хамтран ажиллаж, уян хатан байх нь аливаа зөрчлөөс хамгаалж, урагш тэмүүлэхэд нь тусалдаг.

Комплайнсын ажилтан компанийн бусад этгээдтэй харилцаа холбоотой байж, эелдэг, найрсгаар хамтран ажиллах хэрэгтэй. Комплайнс нь хүн бүрийн дуртай сэдэв биш ч комплайнсын ажилтан бусдын санаа бодлыг төвөгшөөлгүйгээр сонсож, түүнд тохирсон хариу үйлдлийг үзүүлэх нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг. Түүнчлэн бусадтай харилцан ойлголцох замаар комплайнсыг “саад” гэсэн ойлголтыг арилгах нь хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх нь зөв алхам болно.

Ингэснээр хамт олон түүнийг сонсох бөгөөд бусдын санаа бодол, байгууллагын соёл, тухайн нөхцөл байдлыг харгалзан бизнесийн үйл ажиллагааны найдвартай байдлыг алдагдуулахгүйгээр асуудлын зөв хариултыг олох нь комплайнсын ажилтны үүрэг юм.

Асуудлыг нарийвчлан авч үзэх


Аливаа асуудалд тун анхааралтай хандаж, тэдгээрийг нарийвчлан үзэх нь комплайнсын ажилтны маш чухал чадвар. Ганцхан жижиг алдаа байгууллагын нэр хүндийг унагах, эсвэл их хэмжээний торгууль төлөх эрсдэлд хүргэж болзошгүй.

Хэрэв зохицуулалтад гарч буй өөрчлөлтүүдэд тухай бүр анхаарал хандуулан ажиллаж чадвал асуудал гарах нь тэр хэмжээгээр багасна.

Шударга, зарчимч байх

Комплайнсын ажилтанд байх ёстой шийдвэрлэх чадвар бол шударга, зарчимч байдал.

Шударга, зарчимч байх гэдэг нь ойлгомжтой хэдий ч ихэнх компаниуд түүнд төдийлөн ач холбогдол өгөлгүйгээр орхигдуулдаг байна. Асуудлыг шийдвэрлэх эцсийн хоромд үүнийг орлох ямар ч зүйл байдаггүй ба комплайнсын ажилтан ажилдаа ёс суртахуунтай, зарчимч, үнэнч байх шаардлагатай.



Эх сурвалж: <https://www.linkedin.com/>

ФИНТЕК БА РЕГТЕК

КРИПТОВАЛЮТЫН ҮНДСЭН ТӨРЛҮҮД

Криптовалют гэдэг нь криптографаар мэдээлэл нууцлагдсан, компьютерын сүлжээнд оршдог, аливаа нэгэн улсын төв банкны удирдлага, хяналтад ажилладаггүй чөлөөт валют юм. CoinMarketCap-ийн мэдээлснээр ойролцоогоор 22,932 криптовалюта байгаа бөгөөд нийт зах зээлийн үнэлгээ нь 1.1 их наяд ам.доллар байна. Монгол Улсын хувьд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 12 ВХҮҮ (виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч) Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдсэн арилжаалагдаж байгаа бөгөөд дотоодын виртуал хөрөнгийн бөгөөд эдгээрээр дамжуулан дотоодын 41, ОУ-ын 170 гаруй койн, токен байгаа нийт зах зээлийн үнэлгээ 263.9 тэрбум төгрөг байна.

Энэ нийтлэл нь өргөн хүрээнд ойлгох бөгөөд криптовалютыг дөрвөн том төрөлд ангилахад туслах болно.

1. Payment cryptocurrency буюу төлбөрийн криптовалюта

Энэ төрлийн криптовалюта бол төлбөрийн криптовалюта юм. Биткойн бол хамгийн алдартай криптовалюта болон дижитал төлбөрийн криптовалютын анхны амжилттай жишээ юм. Төлбөрийн криптовалютын зорилго нь арилжааны хэрэгсэл төдийгүй гүйлгээг хөнгөвчлөх цэвэр цахим бэлэн мөнгө юм.

2. Tokens буюу токен

Токенууд нь блокчейн мэдээллийн санд хадгалагдсан тоон хөрөнгө юм. Эдгээр нь аль хэдийн бий болсон блокчейн дээр бүтээгдсэн бөгөөд ихэвчлэн хөрөнгийг төлөөлөх эсвэл эзэмшигчид тодорхой үйлчилгээ эсвэл программ руу нэвтрэх боломжийг олгодог. Токен бол хөрөнгө, хэрэгслийг төлөөлөх дижитал нэгж юм.

Токенуудын төрлүүд:

- ◆ Үнэ цэний токенууд (Value tokens): Эдгээр төрлийн токенууд нь NFT хэлбэрээр урлаг, хөгжим гэх мэт дижитал хөрөнгөд суурилсан үнэ цэнэ бүхий зүйл юм.
- ◆ Хэрэглээний токенууд (Utility tokens): Эдгээр нь үйлчилгээ үзүүлэхэд тусалдаг токенууд юм. Тэд хэрэглэгчдэд блокчейн сүлжээ эсвэл төвлөрсөн бус программ дээр үйлдэл хийх эрхийг өгдөг.
- ◆ Санхүүгийн токенууд (Security tokens): Энэ төрлийн токен нь хөрөнгийн өмчлөлийг илэрхийлдэг. Компаниуд хувьцааны токеныг зарж хөрөнгө босгохын тулд аюулгүй байдлын токен ашиглаж болно. Эдгээр нь санхүүгийн үнэт цаасны өмчлөлийг төлөөлдөг. Хөрвүүлэх чадвартай тул NFT болон үнэ цэний токеноос ялгаатай.

3. Stablecoins буюу тогтвортой койн

Тогтвортой койн бол өөр хөрөнгийн үнэд холбогдсон криптовалюта юм. Хэрэв зөв ажиллаж байгаа бол АНУ ам.доллартой холбосон тогтвортой койн үргэлж 1 ам.доллараар үнэлэгдэх ёстой. Нэг төрлийн тогтвортой койныг санхүүгийн байгууллага гаргадаг бөгөөд энэ нь тогтвортой койны нэгж тус бүрийг барьцаалж, нөгөө талдаа крипто хөрөнгө нь засгийн газрын үндсэн мөнгөн тэмдэгийн үнэ цэнийг хадгалж үлдэхийн тулд дериватив стратеги ашигладаг.

Тогтвортой койн төрлүүд:

- ◆ Барьцаат тогтвортой койн (Collateralized stablecoins): Барьцаалагдсан тогтвортой зоосон мөнгө нь зоосны үнэ цэнийг дэмжих барьцааны санг хадгалдаг. Хэн нэгэн койн зарах бүрд ижил хэмжээний барьцааг койны нөөцөөс авдаг.
- ◆ Алгоритмын тогтвортой койн (Algorithmic stablecoins): Эдгээр тогтвортой койнууд нь нийлүүлэлтээ хянахын тулд алгоритмуудыг ашигладаг бөгөөд ингэснээр үнэ ханшаа хадгалдаг. Жишээ нь TerraUSD (UST) нь анх Луна хэмээх зоосыг бүтээж устгаснаар 1 ам.доллараар тогтоогдсон байна. TerraUSD-г худалдаж авах эсвэл худалдах бүрд түүний токен болох Luna-г зохих хэмжээгээр үүсгэж эсвэл устгадаг.

4. Central Bank Digital Currencies (CBDC) буюу Төв банкны дижитал валют

Төв банкны дижитал валют нь янз бүрийн орны төв банкнаас гаргасан криптовалютын нэг хэлбэр юм. CBDC-ийг төв банкууд токен хэлбэрээр эсвэл тухайн валюттай холбоотой цахим бүртгэлээр гаргадаг бөгөөд тухайн улс эсвэл бүс нутгийн үндэсний мөнгөн тэмдэгтэй холбодог.

Энэхүү дижитал валютыг төв банкууд гаргадаг тул төв банкууд CBDC-ийн талаарх бүрэн эрх мэдэл, зохицуулалтыг хадгалдаг. Санхүүгийн систем, мөнгөний бодлогод CBDC-ийг хэрэгжүүлэх нь олон орны хувьд эхний шатандаа байна. Гэсэн хэдий ч цаг хугацаа өнгөрөхөд энэ нь илүү өргөн тархсан болж магадгүй юм.

Криптовалютын нэгэн адил CBDC нь төлбөрийн үр ашгийг нэмэгдүүлж, гүйлгээний зардлыг бууруулах боломжтой блокчейн технологи дээр суурилдаг.

Эх сурвалж: Forbes.com, Corporatefinanceinstitute.com, C3X

ФИНТЕК БА РЕГТЕК

ХАМТЫН САНХҮҮЖИЛТ БОЛОН P2P ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

/ӨМНӨХ ДУГААРЫН ҮРГЭЛЖЛЭЛ/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны дарга Б.Батчимэг batchimeg_b@frc.mn
Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны мэргэжилтэн Б.Даваамаа davaamaa@frc.mn

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхийн улс орнуудад P2P зээлийн үйл ажиллагаа болон хамтын санхүүжилтийн бусад төрлийн үйлчилгээний зохицуулалт тухайн улсын хууль, эрх зүй, санхүүгийн системийн онцлогоос шалтгаалан ялгаатай байдаг бөгөөд зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээний тухайд зээл, хөрөнгө оруулалтын үйлчилгээний зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж буй туршлагауд байна. Мөн хандивт суурилсан хамтын үйлчилгээг Хандив/буяны тухай хуулиар, урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг Худалдааны тухай хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулиар зохицуулж буй улс орнууд байна.

АВСТРАЛИ УЛС

Австралийн P2P салбарын хөгжил нь 2016 оны эдийн засгийн уналтын үед Нөөцийн банк бодлогын хүүгээ 1.5 хувь хүртэл бууруулснаас эхлэн хурдтай хөгжиж эхэлсэн. Энэ үеэс хөрөнгө оруулагчид өндөр өгөөж өгөх өөр хөрөнгө оруулалтын хувилбаруудыг хайж эхэлсэн бөгөөд үүнтэй зэрэгцэн технологийн хөгжил, интернэтийн хэрэглээ нэмэгдэж, хэрэглэгчийн хэв маяг өөрчлөгдсөн нь P2P зээлийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн. Хятадыг эс тооцвол Австралийн P2P зах зээлийн хэмжээ 2016 онд 609.59 сая ам.доллар байсан бол 2017 онд 1.14 тэрбум гаруй ам.доллар болж, дунджаар 88 хувиар өссөн бөгөөд Ази Номхон далайн бүс нутагт санхүүгийн зах зээлийн нийт хэмжээгээрээ хамгийн том орон юм. Австрали улсад анхны P2P зээлийн платформ болох "SocietyOne" нь 2010 онд байгуулагдсан билээ. Уг платформ нь Австралийн хамгийн том P2P платформ бөгөөд хөрөнгө оруулагчдын санхүүжилтээр 45,000 австрали доллароос 50,000 австрали долларын хооронд зээл олгодог. Зээлийн өрийг дахин санхүүжүүлэх, амралт, тээврийн хэрэгсэл худалдан авах, хурим санхүүжүүлэх болон бусад хувийн хэрэгцээнд ашиглах зэрэг зориулалтаар авах боломжтой.

Хөрөнгө оруулагчид платформын зээлдэгчид олгосон зээлийн зэрэглэлээс хамааран 6.1 хувиас 22.6 хувийн хооронд өгөөж авах боломжтой. "SocietyOne" нээгдсэнээс хойш барьцаагүй хувийн зээлд төвлөрсөн хэд хэдэн P2P платформууд бий болсон

бөгөөд үүнд "RateSetter" (Их Британид төвтэй группийн нэг хэсэг), "DirectMoney", "MoneyPlace", "Harmony" (Шинэ Зеландад төвтэй P2P платформ) багтана. Мөн жижиг дунд бизнесүүдэд бизнесийн зээл олгоход төвлөрдөг "Marktlend", "Bigstone", "ThinCats Australia" (Их Британид төвтэй группийн нэг хэсэг), "DirectMoney", "OnDeck" (АНУ-тай хамтран ажилладаг P2P платформ) зэрэг P2P платформууд ч байдаг. "Bigstone" нь Австралийн зах зээлд хамгийн сүүлийн үеийн оролцогч бөгөөд жижиг бизнесүүдэд 250,000 австрали доллар хүртэл зээл авах бол хөрөнгө оруулагчид 7–23 хувийн өгөөж хүртэх боломжийг олгодог. "Bigstone" зээл нь "Хувийн өмчийн үнэт цаасны бүртгэлд бүрдгэгдсэн зээлдэгч компанийн хөрөнгөөр баталгаа гаргаж гэрээгээр баталгаажуулсан" ба "зээл бүрийг зээлдэгч захирлууд биечлэн баталгаажуулсан" байхыг шаарддаг.

Австрали дахь P2P зээлийн зохицуулалт, бодлогын шинэчлэл:

Австрали улс 2017 оны Корпорацын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтэд зориулсан тусгай зохицуулалтыг тусгасан. Харин P2P зээлийн хувьд зохицуулалт нь хараахан тодорхой болоогүй бөгөөд P2P зээлийн үйл ажиллагааг уламжлалт аргаар зохицуулдаг.

P2P платформын үйл ажиллагааны тодорхой загвараас хамааран P2P зээлд хамаарах үндсэн зургаан зохицуулалтын хэлбэр

байдаг. Эдгээрийг ерөнхийд нь удирдлага, хөрөнгө оруулалтын схем (“MIS”), Австралийн санхүүгийн үйлчилгээний (“AFS”) зохицуулалт, үнэт цаасны зохицуулалт, Деривативын зохицуулалт, Австралийн зах зээлийн тусгай зөвшөөрөл (“AML”), Хэрэглээний зээлийн зохицуулалт гэж ерөнхийд нь ангилдаг. Зохицуулалтын хэлбэр бүр нь хөрөнгө оруулагчдыг, ялангуяа жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор P2P платформуудад үйл ажиллагааны болон ил тод байдлын тодорхой шаардлагуудыг тавьдаг.

Австралийн санхүүгийн үйлчилгээний зохицуулалт (AFS) ба P2P

зээл: Австрали Улсад P2P зээлд “Санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл” олгодог. Энэ зохицуулалтад P2P платформууд нь хэрэглэгчдийнхээ санхүүгийн байдалд тулгуурлан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, зээлдэгчдэд зээлжих чадварын зэрэглэл тогтоох, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахдаа ашигладаг санхүүгийн харьцаа үзүүлэлтийг гаргаж өгөх, хөрөнгө оруулалтад тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг зөвлөдөг.

Мөн P2P платформууд нь санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой өргөдөл гаргах, захиран зарцуулах, хэлцэл хийх ажлыг зохион байгуулж, хувь хүн хөрөнгө оруулагчдад кастодианы үйлчилгээ үзүүлж болдог.

Австралийн санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй этгээд нь хэрэглэгчийн мөнгө, эд хөрөнгийг эзэмшдэг учраас маш өндөр зохицуулалттай байдаг ба Зохицуулагч байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд дотоод систем, хяналт, санхүү, хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагааны шаардлагуудыг биелүүлэхийг шаарддаг. Үүнд: төлбөрийн чадвар, цэвэр хөрөнгө, хураамж болон мөнгөн хөрөнгөтэй холбоотой шаардлагууд, санхүүгийн бүртгэл хөтлөх болон аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан бэлтгэх зэрэг багтана. Дээрх шаардлагууд нь жижиг хөрөнгө оруулагчидтай харьцдаг эсэхээс үл хамааран бүх санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хамаарна. Тиймээс санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмших шаардлагатай бүх P2P платформууд эдгээр шаардлагыг дагаж мөрдөх ёстой.

Хэрэглээний зээлийн зохицуулалт ба P2P зээл: 2009 оны Хэрэглэгчийн зээлийг хамгаалах үндэсний актын дагуу хэрэглээний зээлийн зохицуулалт нь аливаа чөлөөлөлтөөс бусад тохиолдолд хувь хүнд зээл олгох эсвэл зээлтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарна. Тодруулбал, хэрэглээний зээлийн тухай хууль дараах тохиолдолд хэрэгжинэ.

- ◆ P2P платформ нь хувь хүнд зээл олгох;

- ◆ Зээл нь ахуйн болон өрхийн хэрэгцээ, хөрөнгө оруулалтын зориулалтаар өрхийн үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, засварлах, хөрөнгө оруулалтын зорилгоор орон сууц худалдан авах, шинэчлэх, сайжруулахад зориулагдсан;
- ◆ P2P платформуос зээл олгоход хураамж төлөх;
- ◆ Зээлийн үйлчилгээ үзүүлэгч нь Австралид явуулж буй бизнест зээл олгох. P2P платформ нь зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай;
- ◆ Зээлийн гэрээтэй холбоотой зээл олгогчийн үүргийг гүйцэтгэх, эрхээ хэрэгжүүлэх;
- ◆ Зээлийн гэрээний дагуу зээл олгохыг баталгаажуулах зорилгоор зээл олгогч болон хэрэглэгчийн хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх.

P2P платформ нь зээлдэгчийг хөрөнгө оруулагчтай холбох замаар хэрэглэгчдэд зээлийн туслалцаа үзүүлэх, зээлийн гэрээг баталгаажуулахын тулд хоёр талын хооронд мэдээлэл бэлтгэх, дамжуулах үүрэг гүйцэтгэн хөрөнгө оруулагч болон зээлдэгчийн хооронд зуучлах, эсхүл гуравдагч этгээдийн зээл олгогчийн үүрэг, эрхийг хэрэгжүүлэн зээлийн гэрээний дагуу хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс өр барагдуулах ажиллагааг удирдах бөгөөд эдгээр P2P платформууд зээлийн тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

P2P платформ нь зээлийн тусгай зөвшөөрөлтэй бол хариуцлагатай зээлийн заалтыг /responsible lending provisions/ дагаж мөрдөнө. Хариуцлагатай зээлийн зорилго нь ухаалаг зээл олгохыг дэмжих, хариуцлагагүй зээл олгосон зээл олгогчдод хариуцлага хүлээлгэхийг хэлнэ. Зээлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь зээлийн гэрээ хэрэглэгчдэд тохирсон эсэхэд урьдчилсан үнэлгээ хийх шууд үүрэг хүлээдэг. Урьдчилсан үнэлгээг хийхдээ зээлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хэрэглэгчийн шаардлага, зорилго, хэрэглэгчийн санхүүгийн байдлын талаар үндэслэл бүхий лавлагаа гаргаж, хэрэглэгчийн өгсөн мэдээллийг баталгаажуулах шаардлагатай.

Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүргээ биелүүлэх боломжгүй эсвэл гэрээ нь хэрэглэгчийн шаардлага, зорилгод нийцэхгүй байх магадлалтай тул зээлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зээлдэгчид зээлийн гарын авлагыг өгөх ёстой. Зээлийн зааварт тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх ерөнхий мэдээлэл, хэрэглэгчийн төлөх аливаа төлбөр, хураамж, зээл олгогчийн талаарх мэдээлэл, маргаан шийдвэрлэх үйл явцтай холбоотой мэдээллүүд багтана. Түүнчлэн зээлийн үйлчилгээ үзүүлж буй P2P платформ нь зээлдэгчдэд зээлийн саналын ил тод байдлыг хангах ёстой. Мөн зээлийн саналын

тодруулгад хэрэглэгчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон зээл олгогчид төлөх нийт шимтгэл, өөрчлөлтийн талаарх мэдээлэл, зээлийн боломжийн тооцоо, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шалтгаалсан аливаа шимтгэл болон эдгээр дүнг тооцох аргыг агуулсан байх ёстой. Түүнчлэн P2P платформ нь шударга ажиллах, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, зээлийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх, зээлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид дотоод болон гадаад маргаан шийдвэрлэх зохицуулалт, үйл ажиллагааг явуулах санхүү, боловсон хүчин, технологийн нөөцтэй байх, эрсдэлийн удирдлагын зохих тогтолцоотой байх, нөхөн олговрын зохих зохицуулалттай байх шаардлагатай.

ХЯТАД УЛС

Хятадын засгийн газар эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжлийг эртнээс чухалчилж ирсний үр дүнд Хятадад дижитал эдийн засаг маш хурдацтай хөгжиж байна. 2020 онд Хятадын дижитал эдийн засаг 39.2 их наяд юань хүрч, 2019 оныхоос 3.3 их наяд юаниар нэмэгдэж, ДНБ-ий 38.6 хувийг эзэлж байна. Хятад улс Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулахад дижитал эдийн засаг чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 5G, үүлэн тооцоолол, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйн зэрэг шинээр гарч ирж буй технологиуд Хятадад өргөн хэрэглэгдэж байна. Хятад улс нь хөгжингүй хотууд төдийгүй хөгжиж буй хотуудаа ч дижитал эдийн засгийг хөгжүүлж байгаа нь “Alibaba”, “Tencent”, “JD” зэрэг хамгийн алдартай цахим худалдааны шинэ бизнесүүдийг хөгжүүлж, дэлхийн хэмжээнд томоохон нөлөө үзүүлж байна.

Краудфандинг болон P2P зээлийн загварын төрлүүд ба түүний зохицуулалт

Зээлд суурилсан хамтын санхүүжилт (P2P зээл): 2007 оны 6 дугаар сард Хятадын анхны P2P зээлийн компани Paipaidai Шанхай хотод байгуулагдаж, Хятадын P2P зээлийн салбар бий болж эхэлсэн. 2014 оны эхээр зарим P2P зээлийн платформууд хууль бусаар хөрөнгө босгож, хэрэглэгчдийн итгэлийг алдан уналтад орсон.

Иймээс 2015 онд P2P зээлийн залиланг таслан зогсоох, зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор Хятадын Ардын банк (PBC) болон 10 эрх баригчид интернэт санхүүгийн хөгжлийг дэмжих удирдамж гаргасан. Удирдамжид цахим зээлд хувь хүний цахим зээл (жишээ нь P2P зээл) болон цахим бичил санхүү багтана гэдгийг онцолсон. Харин P2P зээлийн үйл ажиллагаа нь хувийн зээлийн ангилалд хамаарах бөгөөд тус зээл нь Гэрээний тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг. P2P зээлийн платформ нь зөвхөн хөрөнгө

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн зохицуулалт:

Австралийн урамшуулалд суурилсан санхүүжилт нь Австралийн Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо (ASIC) болон Корпорацийн тухай хуулиар зохицуулагддаг. Тухайлбал, урамшуулалд суурилсан хамтын санхүүжилт нь тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд Корпорацийн тухай хуулийн дагуу тодорхой зохицуулалтын шаардлагаас чөлөөлөгддөг. Гол чөлөөлөлтөд албан ёсны мэдээлэл өгөх баримт бичиг шаардлагагүй, хөрөнгө босгох тусгай зөвшөөрлийн шаардлагад хамрагдахгүй байх, хөрөнгө босгох хязгаарлалтыг зөрчихгүйгээр олон тооны хүмүүсээс хөрөнгө босгохыг зөвшөөрдөг.

оруулагчид болон санхүүжилт хүсэгчдэд мэдээллийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх ёстой бөгөөд тэд зээлийн үйлчилгээ үзүүлэх, хууль бусаар хөрөнгө босгохыг хориглосон. 2016 онд Хятадын засгийн газар онлайн зээлийн зуучлагчийн үйл ажиллагааны түр зохицуулалтыг нэвтрүүлсэн. Энэхүү түр журамд P2P зээлийн мэдээллийн зуучлагчдад дараах үүргийг биелүүлэхийг шаарддаг:

- ◆ зээлдүүлэгч болон зээлдэгчдийн зээлийн мэдээлэл цуглуулах, ангилах, платформд нийтлэх, түүнчлэн зээлийн үнэлгээ, зээлийн тохирол, санхүүжилтийн зөвлөгөө өгөх, маргааныг платформуор шийдвэрлэх, бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх;
- ◆ зээлдүүлэгч болон зээлдэгчийн нөхцөл байдал, мэдээллийн үнэн зөв эсэх, санхүүжилтийн төслийн үнэн зөв, хууль ёсны эсэхэд зохих шалгалтыг хийх;
- ◆ залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэх, залилан мэхлэх болон зээлдүүлэгчийн эрх ашгийг хохироож буй бусад нөхцөл байдлыг илрүүлэх арга хэмжээ авч, холбогдох онлайн зээлийн үйл ажиллагааг нэн даруй зарлаж, зогсоох;
- ◆ хөрөнгө оруулагчдад P2P зээл болон холбогдох эрсдэлүүдийн талаар мэдлэг олж авахад нь тусалж, мэдээллийн нээлттэй байдлыг бэхжүүлэх, зээлдүүлэгчдийг төвлөрсөн бус хэлбэрээр онлайн зээлд оролцоход чиглүүлэх, зээлдүүлэгчид зээлийн эрсдэлийн талаар бүрэн мэдлэг, мэдээлэлтэй байлгахад тусална;
- ◆ цахим зээлийн үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл, өрийн талаарх мэдээллийг хууль тогтоомж, холбогдох зохицуулалтын дагуу холбогдох статистикийн хэлтэст тухай бүрд нь гаргаж, бүртгүүлэх;
- ◆ Зээлдүүлэгч болон зээлдэгчийн гүйлгээний мэдээллийг зохих ёсоор хадгалах, устгах, өөрчлөхгүй байх,

зээлдүүлэгч болон зээлдэгчийн хувийн мэдээлэл, гүйлгээний мэдээллийг хууль бусаар арилжаалах, задруулахгүй байх;

- ◆ харилцагчийг таних, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, үйлчлүүлэгчийн мэдээлэл, гүйлгээний бүртгэлийг хөтлөх зэрэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлэх;
- ◆ санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажлыг сайн гүйцэтгэхийн тулд хууль эрх зүйн байгууллагуудтай хамтран ажиллана;
- ◆ холбогдох шаардлагын дагуу интернэтийн мэдээллийн агуулгыг удирдах, сүлжээний аюулгүй байдлыг хангах.

Хятадын засгийн газрын P2P зээлийн эрсдэлийг бууруулах бодлогыг гурван үе шатанд хувааж хэрэгжүүлсэн.

Эхний үе шат: /2015.10–2017.8/

Дээр дурдсанчлан Хятадын Ардын банк (PBC) болон 10 эрх баригчид 2015 оны 10 дугаар сард Интернэт санхүүгийн хөгжлийг дэмжих удирдамж гаргасан нь P2P зээлийн эрсдэлийг бууруулах эхлэлийг тавьсан. 2016 оны 4 дүгээр сараас Хятадын засгийн газар P2P зээлийн эрсдэлийг бууруулах тусгай ажлыг эхлүүлж харьяаллын дагуу P2P зээлийн платформыг мэдээллийн зуучлалын стандартыг хангаж байгаа эсэхийг 2016 оны 11 дүгээр сар гэхэд судалж дуусгахыг харьяа зохицуулах байгууллагуудад үүрэг болгосон. 2016 оны 4 дүгээр сарын 13–ны өдөр Хятадын Банкны Зохицуулах Хороо "P2P зээлийн эрсдэлийг бууруулах тусгай ажлын хэрэгжилтийн төлөвлөгөө"-г гаргасан бөгөөд үйл ажиллагааны дараах стандартыг дэвшүүлсэн:

- ◆ Платформ нь P2P зээл олгох шаардлагыг хангасан байх;
- ◆ Мэдээллийн зуучлагч;
- ◆ Хууль бусаар хөрөнгө босгохыг хориглох;
- ◆ Хөрөнгийг гуравдагч этгээд удирдах;
- ◆ Мэдээллийг задруулахгүй байх арга хэмжээг авсан байх.

Гэсэн хэдий ч P2P зээлийн эрсдэлийг бууруулах тусгай ажлын удаашралтай байдлаас шалтгаалан 2016 оны 11 дугаар сар гэхэд ажил бүрэн дуусаагүй.

Хоёр дахь шат: /2017.9–2018.6/

2017 оны 9 дүгээр сард эрх баригчид дараагийн шатны хэрэгжилтийн төлөвлөгөөг гаргаж, өмнөх шатны ажлыг нэгтгэн дүгнэж, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхэд бизнес нь өсөх боломжгүй бөгөөд зөрчилтэй платформын тоо нэмэгдсэн. 2017 оны 12 дугаар сард орон нутгийн засаг захиргаа P2P онлайн зээлийн платформыг 2018 оны 6 дугаар сарын 30–ны өдрийн дотор хүлээн авч, бүртгэлжүүлсэн.

Гурав дахь шат: /2018.07 – өнөөг хүртэл/

Гурав дахь шат нь 2018 оны 7 дугаар сараас өнөөг хүртэл хэрэгжиж байна. Учир нь өмнөх хийгдэж байсан ажил дуусаагүй учраас Эрх баригчид P2P зээлийн асуудлыг шийдвэрлэх хугацааг сунгасан. Үүний дараа эрх баригчид P2P зээлийн платформын шалгалтын хэрэгжилтийн тухай мэдэгдэл болон хяналтын хуудсыг 5 хэсэг, 37 ангилал, 108 зүйлд хуваасан P2P зээлийн платформуудын сөрөг/ negative жагсаалтын стандартуудыг жагсаасан.

Санхүүгийн зохицуулагчид болон Интернэт санхүүгийн холбоод "Цахим зээлийн мэдээллийн зуучлагчийн удирдамж" гаргасан бөгөөд P2P зээлийн салбарт шат дараатай авсан үйл ажиллагаа нь үр дүнд хүрч шаардлага хангахгүй 1200 орчим байгууллагын үйл ажиллагааг зогсоосон байна.

Хандивт суурилсан хамтын санхүүжилт

Энэхүү хамтын санхүүжилт нь хандивт суурилдаг тул санхүүжүүлэгч (хандивлагч) ямар ч хариу төлбөр, ашиг авдаггүй. 2018 онд Хятадын Иргэний хэргийн яамнаас 20 онлайн хандивын платформыг Буяны тухай хуулийн дагуу баталгаажуулж, улс даяар 1400 гаруй хамтын буяны байгууллагын 21,000 төсөлд 3.17 гаруй тэрбум юанийн хандив цуглуулсан ба энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 26 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин Ковид–19–ийн үед платформуор дамжуулан 49.54 сая хандивлагчдаас 1.86 тэрбум юанийг цуглуулсан байна. Хятадад хамгийн алдартай хандивт суурилсан хамтын санхүүжилтийн платформуудад Шуйдчоу (水滴筹) болон Чинсончоу (轻松筹) багтдаг. Шуйдчоу санхүүгийн хүндрэлтэй хүнд өвчтэй 800 мянга гаруй өвчтөнд үнэ төлбөргүй хандив цуглуулах үйлчилгээг амжилттай эхлүүлсэн бөгөөд нийт 10 гаруй тэрбум юанийн хандив цуглуулж, 340 сая гаруй хүнд тусламж үзүүлсэн.

Мөн Хятадын хандивт суурилсан хамтын санхүүжилтэд залилан мэхлэх, завших гэмт хэрэг түгээмэл тохиолддог. Жишээлбэл, Шуйдчоу хандивын платформуор дамжуулан цуглуулсан 150,000 гаруй юанийг хүүхдийн эцэг ноён Мо өвчтэй хүүхдүүдийн эмчилгээнд зориулаагүй өөр зориулалтаар ашигласан тул 2019 оны 11 дугаар сарын 6–ны өдөр түүнийг шүүхэд өгсөн. Ноён Мо хандив хувийн өвчний хандив цуглуулах төслийг санаачилж төсөлд нийтдээ 153,136 юань цуглуулсан бөгөөд хандивын мөнгөө тохиролцсоны дагуу хүүгийнхээ эмчилгээний зардлыг төлөхөд ашиглаагүй ч хүүгийнхээ эмчилгээний өрийг төлөхөд зарцуулсан байна. Гэсэн хэдий ч шүүх ноён Мо–г өөрийн өмч хөрөнгө, нийгмийн бусад тусламжаа нуун дарагдуулж, тохиролцсон зориулалтыг зөрчиж, цугларсан хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан нь гэрээг/ бэлэглэлийн гэрээтэй гэж үзээд/ зөрчсөнд тооцсон. Тиймээс ноён Мо 153,000 гаруй юанийг

Шуйдичоу платформд бүрэн буцаан өгч, холбогдох хүүг төлсөн. Шуйдчоу буцааж авсан мөнгөө хандивлагчид руу буцаан олгосон.

Хятад улс Иргэний хууль болон Буяны тухай хуулийн дагуу хандивт суурилсан хамтын санхүүжилтийг зохицуулдаг бөгөөд Буяны тухай хуульд зааснаар зөвхөн бүртгэлтэй, хамтын хандив цуглуулах эрхтэй буяны байгууллагууд хандивыг шууд хүлээн авах боломжтой. Мөн Хятадын платформуор хөрөнгө босгох тусгай журмын дагуу платформ дээр хандив цуглуулж буй байгууллага нь хөрөнгө босгох эрх бүхий буяны байгууллага байх ёстой. Хандивын платформ нь буяны байгууллагын бүртгэлийн гэрчилгээ, хөрөнгө босгох тусгай гэрчилгээг баталгаажуулдаг. Харин хандивын платформ нь хөрөнгө босгох эрхгүй байгууллага бөгөөд хувь хүмүүст мэдээллийг ил тод болгох үйлчилгээ үзүүлдэггүй. Учир нь платформ хувь хүн тусламж хүсэх, харилцан туслалцаа үзүүлэх буяны сан биш юм.

Тэгэхээр Шуйдчоу, Чинсончоу нь буяны байгууллага биш харин буяны мэдээллийн платформ гэсэн үг юм. Эдгээр платформын операторууд хандивтай шууд харьцдаггүй, хандивыг бүрэн цугларахаас өмнө мөнгийг арилжааны банкны тусгай дансанд хуримтлуулж, бүрэн цугларсны дараа хүлээн авагчид руу шилжүүлдэг. Мөн хамтын хөрөнгө босгох платформын журмын дагуу буяны мэдээллийн платформ нь мэдээллийг баталгаажуулах хариуцлага хүлээдэггүй бөгөөд буруу ташаа мэдээлэл өгсөн, эсхүл мэдээллийг зориудаар нуун дарагдуулсан өргөдөл гаргагчдыг платформуос хатуу шалгадаггүй.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилт

Хятадад хамгийн өргөн хөгжсөн краудфандингийн хэлбэр бол урамшуулалд суурилсан краудфандинг юм. Хятадын алдартай интернэт компаниуд “JD.com” болон “Xiaomi” нь өөрсдийн бүтээгдэхүүнд зориулсан платформтой бөгөөд “Xiaomi” хамтын санхүүжилтээр хөрөнгө босгож санхүүждэг. Энэ нь уг компанийн хувьд борлуулалтын хэрэгсэл болон сурталчилгааны хэрэгсэл болж өгдөг. 2015 онд болсон сурталчилгааны арга хэмжээний үеэр “Xiaomi” хамтын санхүүжилт ашиглан “Taobao” дээр 3.59 сая ам.доллар цуглуулж, дээд амжилт тогтоосон. Xiaomi-ийн хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүний нээлтийн үеэр Xiaomi нь CyberDog хэмээх роботыг хөгжүүлж байгаагаа зарлаж, зөвхөн дизайныг нь гаргасан бүтээгдэхүүнд хамтын санхүүжилтийн ажлыг эхлүүлсэн.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн гол асуудал бол төслийн ивээн тэтгэгч болон хэрэглэгчдийн хоорондох мэдээллийн тэгш бус байдал юм. Төслийн ивээн тэтгэгчид урамшууллын бүтээгдэхүүний гүйцэтгэл, инновац, функциональ байршил, боломжит гэмтлүүдийн талаар мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч өгдөг бол хэрэглэгчдийн хувьд бүтээгдэхүүн дээр

гарч болзошгүй худал суртал ухуулгын талаар олж тогтооход бэрхшээлтэй байдаг. 2015 онд гарсан Big Cola гар утасны хэрэг Хятадын нийгмийн анхаарлыг урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтэд татсан. 2015 онд 18,543 санхүүжүүлэгч Big Cola гар утасны хамтын санхүүжилтэд оролцож, нийтдээ 16,812,300 юанийн хөрөнгө оруулалт хийсэн. Гэрээнд зааснаар хамтын санхүүжилтийн төсөл албан ёсоор дууссаны дараа эхний ээлжийн 10,000 санхүүжүүлэгчид жил бүр гар утас үнэгүй авч, Big Cola гар утасны төслийн үйл ажиллагаанд оролцох байсан. Гэсэн хэдий ч төсөл дампуурч, төсөл хэрэгжүүлэгчид амлалтаа биелүүлээгүй бөгөөд санхүүжүүлэгчид утсаа авч чадаагүй байна. Энэ тохиолдол нь краудфандинг үйл ажиллагааны платформын хариуцлагын тодорхойгүй байдлыг илчилсэн.

Хятадын урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн хувьд Цахим худалдааны хууль болон Иргэний хуулийн борлуулалтын гэрээний зохицуулалтыг ерөнхийд нь мөрддөг хэдий ч тусгайлсан зохицуулалт байдаггүй. Цахим худалдааны платформууд хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглахдаа хууль тогтоомж, захиргааны дүрмийг дагаж мөрдөх ёстой. Цахим худалдааны платформ нь хэрэглэгчийн мэдээллийг асуулгах, засварлах, устгах, бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ авах эрхтэй хэдий ч хэрэглэгчийн мэдээллийн лавлагааг засварлах болон устгах хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн мэдээллийг баталгаажуулсны дараа засварлах, эсхүл шууд устгах үүрэг хүлээдэг. Хэрэв хэрэглэгч дансаа хаасан бол цахим худалдааны платформ хэрэглэгчийн мэдээллийг нэн даруй устгах ёстой. Зохицуулагч байгууллага нь цахим худалдааны платформуос ирүүлсэн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдгээрт байгаа хувийн мэдээлэл, нууцлал, худалдааны нууцыг чандлан хадгалах, бусдад задруулах, худалдах, хууль бусаар ашиглахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг.

ЯПОН УЛС

АНУ-д P2P зээл хөгжиж эхэлсний дараа Финтек стартапууд Японд P2P зээлийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч Японы P2P зээлийн үйлчилгээ нь зах зээл, хууль эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөгдөж амжилттай хөгжиж чадаагүй ч эсрэгээр хандив, худалдан авалт, хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь Японд ихээхэн өргөжиж байна.

2020 оны 01 дүгээр сард эхэлсэн Ковид-19 нь санхүүжилтийн өөр хувилбар болох краудфандингийн ач холбогдлыг илүү бататгаж өгсөн. Япон улсад зарласан Ковид-19-ийн онц байдал бусад улс орных шиг хатуу биш хэдий ч ихэнх мужууд ресторан, паб болон театр, клуб, болон бусад хүмүүс ихээр цуглардаг

бизнесүүдийн үйл ажиллагааг хязгаарласан. Энэ үед аж ахуйн нэгжүүд борлуулалтаа алдаж, бизнесүүд алдагдалд орж эхэлсэн төдийгүй энэхүү хүнд нөхцөлийг даван туулахын тулд хамтын санхүүжилт авч эхэлсэн. Бизнес эрхлэгчид Ковид-19-ийн үед үйлчлүүлэгчдийг татах оролдлого хийхийн оронд Ковид-19 дууссаны дараа эзэмшигчдэд үйлчилгээг үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй үнээр ашиглах боломжийг олгодог купон тарааж тэдгээр купоныг урамшуулалд суурилсан краудфандингийн платформ ашиглан зарсан аж. Nikkei-ийн мэдээлснээр 2020 оны 5 дугаар сард онц байдал зарласнаас хойш 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл хамтын санхүүжилтийн тоо 1.4 дахин нэмэгдсэн. Ковидын үеийн краудфандингийн хамгийн том төсөл нь Readyfor платформоор дамжуулсан "Ковид-19 тусламжийн сан" нэртэй хандивын төсөл бөгөөд ойролцоогоор 872 сая иен цуглуулсан.

Мөн урамшуулалт санхүүжилт нь хандивын санхүүжилттэй харьцуулахад хөрөнгө оруулалт хийсний хариуд урамшуулал, хөнгөлөлт амладаг тул Япон улсын хөрөнгө оруулагчид хандивт суурилсан краудфандинг хийхээс илүүтэйгээр урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийг хийх сонирхол ихтэй байдаг. Тиймээс Японд Campfre, Readyfor, Makeake зэрэг хамтын санхүүжилтийн тэргүүлэгч бизнесүүд энэ төрлийн үйлчилгээг үзүүлэхэд идэвхтэй оролцдог. Харин платформын хувьд хөрөнгө босгогчид болон хувь хүний хөрөнгө оруулагчдын хооронд тохирсон төслийг санал болгодог бөгөөд хөрөнгө босгогч зорилтот дүнг цуглуулсны дараа платформ хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх шимтгэлийг авдаг. Цаашлаад урамшуулалд суурилсан краудфандинг нь зөвхөн хөрөнгө босгох платформ төдийгүй зар сурталчилгааны хэрэгсэл болдог. Платформ дээр зах зээлд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг тайлбарласан төслийг оруулснаар хөрөнгө босгогч өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үр дүнтэй сурталчилж, зах зээлийн хэмжээг урьдчилан хэмжих боломжтой. Энэ нь Японд худалдан авалтын төрлийн краудфандинг маш их алдартай болсон нэг шалтгаан юм.

Харин зээлийн хамтын санхүүжилтийн хувьд Япон улсад Maneo, AQUISH, болон SBI Social Lending зэрэг хэд хэдэн платформууд байдаг. Япон дахь P2P зээлийн платформууд нь өөрсдийгөө "нийгмийн зээл" хэмээн тодорхойлдог. Өөрсдийгөө ингэж нэрлэх болсон шалтгаануудын нэг нь Япон дахь зээлийн хамтын санхүүжилт нь бусад улс орнуудаас ялгаатай байдаг оршино. Бусад улсын P2P зээлийн платформ нь хувь хүн хөрөнгө оруулагчдыг, зээлдэгчтэй холбох боломжтой байдаг ч Япон дахь P2P зээлийн хувь хүн хөрөнгө оруулагчид уламжлалт арилжааны банкнуудаар дамжуулсан зээл шиг мөнгөө хэнд олгож байгаагаа таньж чадахгүй. Япон улсын хөрөнгө оруулагчдын хувьд P2P

зээлийн хүү банкны хадгаламжаас өндөр хүүтэй байдаг нь P2P зээлд хөрөнгө оруулах гол хүчин зүйл болдог. Тиймээс P2P зээлийн платформууд нь зээлээр дамжуулан нийгэмд эерэг нөлөө үзүүлж, улам олон хөрөнгө оруулагчдыг татахыг хичээдэг.

Япон дахь Краудфандингийн зохицуулалт

Зээлд суурилсан хамтын санхүүжилт/ P2P зээлийн журам

Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн хөрөнгө оруулагчдын эрхийг Санхүүгийн хэрэгсэл, биржийн тухай хуулиар, хөрөнгө босгогч буюу зээлдэгчийг эрх ашгийг Мөнгөн бизнесийн тухай хуулиар хамгаалдаг. Өөрөөр хэлбэл, Япон улсын зээлд суурилсан хамтын санхүүжилтэд зориулсан тодорхой хууль дүрэм журам байхгүй гэсэн үг юм.

Зээлд суурилсан краудфандингийн үндсэн механизм нь зээлдүүлэгч болон зээлдэгч хоёрын хооронд байгуулсан зээлийн гэрээ байх боловч зээлдүүлэгч зээлдэгчдэд мөнгөө шууд зээлэхгүй бөгөөд платформ болон хөрөнгө оруулагчид ТК гэрээ буюу чимээгүй түншлэлийн гэрээ байгуулдаг. Уг гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулагчид нэрээ нууцлах ба платформ нь хөрөнгийг удирдах үүргийг гүйцэтгэдэг. Тэгэхээр эрх зүйн хувьд зээлийн гэрээний талууд нь платформ (зээлдүүлэгч) ба зээлдэгч байна. Үүнийг Японы P2P зээлийн ТК схем гэж нэрлэдэг.

Мөнгөн зээлийн бизнесийн тухай хуулийн дагуу платформ дараах шаардлагыг хангана:

- ◆ Мөнгөн зээлийн бизнес эрхлэхээр төлөвлөж буй платформ нь Ерөнхий сайдад хандан бүртгүүлэх (Мөнгөний зээлийн бизнесийн тухай хуулийн 3 (1) зүйл).
- ◆ Платформ нь мөнгө зээлдүүлэгчийн хувьд зээлийн гэрээний талаарх мэдээллийг зээлдэгчид бичгээр мэдээлэх үүрэгтэй (14, 15, 16, 16-2, 16-3, 17, 18 дугаар зүйл). Үүнд: хүүгийн түвшин болон өрийн нийт дүнгийн хязгаар багтана.
- ◆ Платформ нь зээлдэгчийг хамгаалахын тулд Мөнгөн зээлийн бизнесийн тухай хуулийн 12-6, 12-7, 12-9, 13, 13-2, 13-3, 13-4, 20, 20-2, 21, 22, 24, 24-2, 24-3, 24-4, 24-5 стандартуудыг дагаж мөрдөнө.
- ◆ Платформ нь Мөнгөн зээлийн бизнесийн тухай хуулийн 12-3, 12-4, 12-5, 19, 19-2, 23-д заасан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

Хэрэв платформ Мөнгөн зээлийн бизнесийн тухай хуулийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Ерөнхий сайд болон холбогдох байгууллагууд платформын эсрэг захиргааны шийтгэл эсвэл бизнесийн үйл ажиллагааг зогсоох хүртэл хариу арга хэмжээ авах эрхтэй.

Харин Санхүүгийн хэрэгсэл ба биржийн тухай хуульд корпорацийн хувьцаа, бонд, хамтын хөрөнгө оруулалт, брокеруудад зориулсан өөр өөр зохицуулалтыг тогтоодог. ТК гэрээгээр хөрөнгө оруулалт хийх нь хамтын хөрөнгө оруулалтын схемийн нэг төрөл гэж тооцогддог тул зээлийн платформ нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн платформын хувьд Санхүүгийн хэрэгсэл, биржийн тухай хуулийн зохицуулалтад хамаарна. Санхүүгийн хэрэгсэл ба биржийн тухай хуульд хамтын хөрөнгө оруулалтын сангийн бизнес эрхлэгчдийг Санхүүгийн зохицуулагч байгууллага (цаашид FSA гэх) бүртгүүлэхийг шаарддаг ба FSA нь хамтын сангийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Санхүүгийн хэрэгсэл, биржийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд захиргааны шийтгэл ногдуулдаг. Хөрөнгө оруулагчдын сангийн платформоор бүртгүүлэхийн тулд зээлийн платформ нь дүрмийн сан (хамгийн багадаа арван сая япон иен) бий болгох, зохих зарчим, тайлбар өгөх үүрэг зэрэг стандартыг дагаж мөрдөх, хуулийн 29–4 дугаар зүйлд заасны дагуу бизнесийн үйл ажиллагааны зохистой схемийг бий болгох шаардлагатай.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн зохицуулалт

Япон улсад урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийг зохицуулах хууль эрх зүйн хоёр хувилбар бий. Эхнийх нь платформ (худалдагч) болон хөрөнгө оруулагч (худалдан авагч) хоорондын борлуулалтын гэрээ (тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ) юм. Платформ болон хөрөнгө оруулагчийн хоорондох гэрээ нь энгийн борлуулалтын гэрээ хэлбэртэй байж болох тул онлайн борлуулалтын нэг хувилбар гэж үзэн платформуыг тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдагчийн хувьд арилжааны гүйлгээний тухай хуулиар зохицуулдаг. Энэхүү зохицуулалтын зорилго нь хэрэглэгчид үндэслэлгүй, буруу дүгнэлт хийх, худалдагч залилан мэхэлсэн гүйлгээ хийхээс хэрэглэгчдийг хамгаалахад оршино. Платформ уг хуулийг зөрчсөн тохиолдолд платформын эсрэг бизнесийн үйл ажиллагааг сайжруулах тушаал, бизнесийг түдгэлзүүлэх зэрэг захиргааны шийтгэл ногдуулдаг (арилжааны гүйлгээний тухай хуулийн 14, 15 дугаар зүйлд зааснаар).

Зохицуулалтын хоёр дахь хувилбарын эхний хувилбараас ялгаатай нь хөрөнгө босгогч (худалдагч) болон хөрөнгө оруулагч (худалдан авагч) хоёрын хооронд байгуулсан борлуулалт эсвэл борлуулалтын захиалгын гэрээ бөгөөд платформ нь зөвхөн хоёр талын хооронд гүйлгээ хийхэд зуучлах үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү зохицуулалтын хүрээнд платформ гэхээсээ илүү хөрөнгө босгогч нь онлайн худалдааны гүйлгээг худалдагчийн хувьд арилжааны гүйлгээний тухай хуулийн зохицуулалтад хамаарна. Тиймээс хөрөнгө босгогч нь платформоор дамжуулан хөрөнгө оруулагчдад шууд мэдээлэл өгөх үүрэгтэй. Дээр дурдсанчлан,

хөрөнгө босгогчид үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд хөрөнгө оруулагчид түүний үнэн зөвийг хянадаг. Тиймээс үүнийг хамтын санхүүжилтийн тохиромжтой бөгөөд үр дүнтэй схем гэж үздэг. Хэдийгээр платформ нь хөрөнгө оруулагчийн өмнө хариуцлага хүлээхгүй ч тус платформ нь туслах талын хувьд хөрөнгө босгогчтой (залилан) хамтран хөрөнгө оруулагчийн өмнө хариуцлага хүлээх боломжтой байдаг.

Хөрөнгө оруулагчдыг (худалдан авагч) хамгаалах зохицуулалтаас ялгаатай нь хөрөнгө босгогчийг хамгаалах тусгай хууль тогтоомж байдаггүй. Тэдэнд зөвхөн иргэний хуулийн ерөнхий журмууд л үйлчилдэг. Жишээлбэл, платформ нь хөрөнгө босгогчид буруу мэдээлэл өгсөн эсхүл хөрөнгө босгогчийг хууран мэхэлж, ашиггүй гэрээ байгуулсан бол уг платформ нь зөвхөн ерөнхий гэрээ (Иргэний хуулийн 415 дугаар зүйл) эсвэл зөрчлийн хуулиар (Иргэний хуулийн 415 дугаар зүйл) хөрөнгө босгогчдод хариуцлага хүлээлгэдэг.

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн зохицуулалт

Японы хөрөнгө оруулагчид нь хандивын аянд нэлээдгүй болгоомжтой ханддаг тул хандивлагчдыг ятгаж хөрөнгө босгохын тулд хандив цуглуулагчид болон платформууд шаргуу ажиллах шаардлагатай байдаг. Хандивт суурилсан хамтын санхүүжилтийг бусад хамтын санхүүжилтийн хэлбэрүүдтэй харьцуулахад зүй бусаар ашиглах, залилан мэхлэх эрсдэл нь харьцангуй бага байдаг. Тиймээс хандивын хамтын санхүүжилт, хөрөнгө оруулагчдад тусгай шалгуур тавих шаардлагагүй бөгөөд платформ ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тухайлбал, хандив цуглуулагчид зээлээ төлнө гэж амладаггүй ба платформ тэдний төсөлд хяналт тавьдаггүй. Тэдний хийх ёстой зүйл бол хандивын үр дүн болон үйл ажиллагааны талаар төсөл хэрэгжиж дууссаны дараа мэдээлэх юм. Тиймээс хандивт суурилсан хамтын санхүүжилтийн хандивлагчид болон хандив цуглуулагчдын эрх ашгийг хамгаалах шаардлагагүй. Иймээс Японд хандивын платформын хувьд тусгай зохицуулалт байдаггүй. Гэсэн хэдий ч хандив цуглуулагч хандивын хамтын санхүүжилтийн платформоор тодорхой бус, буруу ташаа мэдээлэл тараасан, эсхүл хандив цуглуулагч нь хандивлагчтай холбоотой гэрээг зөрчсөн тохиолдолд иргэний хуулийн дагуу зөрчлийн хариуцлага хүлээдэг. Нэмж дурдахад, хэрэв платформ нь хандив цуглуулагчийг буруу ташаа мэдээлэл өгөхөд тусалсан бол платформ нь хандив цуглуулагчтай хамтран хариуцлага хүлээдэг.

ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд тохиож буй технологийн дэвшлийн нөлөөгөөр платформуор дамжуулан санхүүжилт босгох хамтын санхүүжилтийн үйлчилгээ түгээмэл нэвтэрч байна. Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь хөрөнгө оруулалтад суурилсан, зээлд суурилсан, урамшуулалт болон хандивын санхүүжилт гэсэн нийтлэг дөрвөн төрөл байдаг.

Олон улсын хувьд хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь АНУ, Канад зэрэг Хойд Америкийн улсууд болон Ази, номхон далайн орнуудад түгээмэл хөгжиж байгаа бөгөөд улс орнууд хамтын санхүүжилтийн үйлчилгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны нэг хэлбэр гэж үзэн үнэт цаасны зах зээлийн зохицуулалтаар, зээл болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тус тусынх нь хуулиар, мөн хамтын санхүүжилтийн тухай тусгайлсан зохицуулалтын хүрээнд зохицуулж байна.

Харин Монгол Улсын хувьд хамтын санхүүжилтийн үйлчилгээтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт хараахан бүрдээгүй ба хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалтыг бий болгохоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох заалтуудыг тусгасан байна.

Иймээс хамтын санхүүжилтийн үйлчилгээний олон улсын зохицуулалтын орчин болон Монгол улсын нөхцөл байдлыг харгалзан үзэж цаашид зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг зохицуулах дараах боломжит хувилбаруудаар зохицуулах боломжтой гэж дүгнэлээ:

- ◆ P2P зээлийн үйлчилгээгээр АНУ, Канад зэрэг Хойд Америкийн улсууд болон Ази, номхон далайн орнууд тэргүүлж буй бөгөөд эдгээр улс орнууд төсөлд зээлээр санхүүжилт татах хамтын санхүүжилтийн үйлчилгээг үнэт цаасны зах зээлийн брокер, дилерийн үйл ажиллагаатай адилтган, эсхүл банк, санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулж байна. Үүнийг манай улсын хувьд тус бүтээгдэхүүн, үйлчилгээг өрийн хэрэгсэл ашиглан санхүүжилт татаж буй хэлбэр гэж тодорхойлон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хамаарах заалтад холбогдох өөрчлөлтийг оруулан тусгаж, зохицуулах;
- ◆ Зээлд суурилсан хамтын санхүүжилт буюу P2P үйлчилгээтэй холбоотой тусгайлсан зохицуулалт буюу “зээлийн үйлчилгээнд хамаарах платформ ажиллуулах үйл ажиллагаа”, эсхүл “зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ” гэсэн хэлбэрээр тодорхойлон Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хуулиудад холбогдох заалтуудыг тусган зохицуулах;
- ◆ Банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалтад бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэлгүйгээр санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулах буюу P2P зээлийн үйлчилгээг эрхлэх зохицуулалтыг тусгах, холбогдох журам, заавар болгон нягтлан бодох бүртгэлийн шаардлагад холбогдох өөрчлөлтийг оруулах;
- ◆ Хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны тухай хуулийг боловсруулан хөрөнгө оруулалт, зээлд суурилсан хамтын санхүүжилт, урамшуулалт болон хандивын санхүүжилт, тэдгээрт зохицуулалт, хяналт тавих эрх бүхий этгээдийг тус тус тодорхойлон зохицуулалтын орчныг бүрдүүлэх.
- ◆ Түүнчлэн хамтын санхүүжилтийн үйлчилгээний зохицуулалтыг бүрдүүлэхдээ дараах зохицуулалт, шаардлагуудыг тусган хэрэгжүүлэх саналыг боловсрууллаа:
- ◆ Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу P2P зээлийн үйлчилгээний платформууд нь хэрэглэгчдийнхээ санхүүгийн байдалд тулгуурлан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, төслийн зээлүүдийн хувьд зээлжих чадварын зэрэглэлийг тодорхойлох, мөн хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахдаа ашиглах санхүүгийн голлох харьцаа үзүүлэлтүүдийг тооцож тайлагнах;
- ◆ P2P зээлийн үйлчилгээний платформуудад хариуцлагатай зээлийн зарчмуудыг дагаж мөрдөх шаардлагыг тавих. Өөрөөр хэлбэл зээлийн гэрээ нь хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага, санхүүгийн боломжит нийцэж буй эсэхийг үнэлэх, зээлдэгчдэд зээлийн үйлчилгээний гарын авлагыг хүргүүлэн танилцуулах. Энд дурдсан зээлийн үйлчилгээний гарын авлагад P2P зээлийн үйлчилгээг эрхлэгчийн ерөнхий мэдээлэл, зээлтэй холбоотой хэрэглэгчийн төлөх төлбөр, хураамжийн нөхцөл, зээл олгогчийн талаарх мэдээлэл, маргаан шийдвэрлэх үйл явцын талаарх мэдээллийг багтаасан байх;
- ◆ P2P зээлийн үйлчилгээг эрхлэгч нь зээлдэгч болон зээлдүүлэгчийн мэдээллийг бүртгэх, ангилах, аюулгүй байдлаар хадгалах, шаардлагатай мэдээллүүдийг ил тод нийтлэх харилцааг зохицуулалтын журам, зааварт дэлгэрэнгүй тусгах;
- ◆ P2P зээлийн үйлчилгээ эрхлэгч нь холбогдох санхүүгийн зөвлөгөө, мэдээллийг хэрэглэгчдэдээ тогтмол хүргэн, маргаан шийдвэрлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх талаарх шаардлагуудыг зохицуулалтын журам, зааварт тусгах;
- ◆ Зээлдэгч, хөрөнгө оруулагчид, худалдан авагч, хэрэглэгчид болон санхүүжилтийн төслүүдийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг шалган магадлах, залилангийн шинжтэй тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх, залилан мэхлэх зөрчил илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулалтын журам, зааварт тусгах;
- ◆ Мэдээллийн аюулгүй байдал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, болон цахим орчин, кибер аюулгүй байдалтай холбоотой бусад шаардлагуудыг заавал тавин мөрдүүлэх зэрэг болно.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №30

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?



Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд зааснаар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгож буй зээлийн үйл ажиллагааг хэлнэ.



Хуулийн этгээд

Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө хэлбэрээр байгуулагдсан.



Монгол Улсын иргэн

Байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу эрх бүхий этгээдэд бүртгүүлсний үндсэн дээр Монгол Улсын Иргэнэрхэлж болно.

Мөнгөн зээлийн үйл
ажиллагаа
эрхлэх этгээд

ХЭЛБЭР

ЭРСДЭЛ БА ХҮҮГИЙН ТҮВШИН



МӨНГӨН ЗЭЭЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ
/2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр/

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Цуврал №30

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



Барьцаа хөрөнгийг хэрхэн үнэлэх вэ?
Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд зээлдэгчтэй харилцан тохиролцож, бодитой үнэлнэ.

Барьцаа хөрөнгийн төрөл

(Зөвхөн хөдлөх хөрөнгө байна)



Тээврийн хэрэгсэл



Цахилгаан хэрэгсэл



Үнэт эдлэл



Гар утас, Нөүтбүүк



Бусад хөдлөх эд хөрөнгө



(Үл хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгохыг хориглоно.)

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ БАЙГУУЛАХДАА ЮУГ АНХААРАХ ВЭ?

- 1 Зээлийн хүү нь ил тод байх ба "Бодлогын зөвлөл"-өөс тогтоосон дээд хэмжээнээс хэтрэхгүй байх
- 2 Нэмэгдүүлсэн хүү нь төлөгдөөгүй үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй
- 3 Зээлийн хүүг ашигласан хугацаагаар тооцно
- 4 Анз буюу алданги, торгууль тооцохгүй.

Барьцаалан зээлдүүлэх газар болон иргэн бүртгэлтэй эсэхийг шалгаарай.

Та зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй бол



Мэдэгдэл хүлээн авна





Хариу өгөхгүй 14 хоног





Барьцаалсан хөрөнгө худалдан борлуулагдана



Барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулснаас үлдсэн хэсэг буцаан олгогдоно.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЭЛХИЙН БАНКНЫ ЭДИЙН ЗАСАГЧИД “2024 ОНД ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГ УДААШРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА” ГЭЖ МЭДЭЭЛЛЭЭ.



ВАШИНГТОН, 2023 оны 10 дугаар сарын 2, Дэлхийн Банкаас гаргасан Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн тайланд дурдсанаар 2023 онд БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.1 хувиар, 2024 онд 4.4 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.



WORLD BANK GROUP

Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн ахлах эдийн засагч Аадитя Маттоо мэдэгдэлдээ: Хятад улс эдийн засгийн өсөлтийг илүү чанаржуулахаар төлөвлөж байгаа боловч өсөлтийг богино хугацаанд хурдасгах талаар бодохгүй байгааг онцлов.” Мөн Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дэд ерөнхийлөгч Мануэла В.Ферро “Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн өсөлт хэдийгээр бага байгаа боловч дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй бүс нутаг хэвээр байгааг мэдэгдэв.

Эх сурвалж: www.wsj.com

ДЭЛХИЙН БАНК БОЛОН ОУВС–ГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ БОЛЛОО .

2023 оны 10 дугаар сарын 9–15–ны өдрүүдэд Марокко улсын нийслэл Маракеш хотод ОУВС– Дэлхийн банкны ээлжит жилийн уулзалт боллоо. Энэхүү уулзалтад 190 гаруй гишүүн орны төлөөлөгчид өргөн хүрээнд чуулж дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлуудыг хэлэлцдэг бөгөөд энэ удаагийн уулзалтаар олон улсын хурцадмал байдлаас шалтгаалан дэлхий нийтэд сорилт болж буй асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд чуулганы үеэр ОУВС–гийн гүйцэтгэх захирал Кристалина Георгиева хэлэхдээ: “Дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд ердөө 3 хувь, ирэх онд 2.9 хувь байхаар төсөөлж байгаа бөгөөд дунд хугацаанд өсөлт бага хэвээр байх төлөвтэй байна. 2020 оноос хойш



тохиолдож буй дараалсан шокууд нь дэлхийн үйлдвэрлэлийг энэ оны байдлаар 3.6 их наяд ам.доллараар бууруулсан. Энэ алдагдал нь улс орнуудад жигд бус тархсан. АНУ–ын хувьд цар тахлын өмнөх түвшинд хэдийн хүрч сэргэсэн бол, дэлхийн бусад улс орнууд сэргэж чадаагүй байна. Бага орлоготой эдийн засгуудын хувьд хамгийн хүнд цохилтыг аваад байна. Инфляц буурч байгаа хэдий ч олон оронд зорилтот түвшнээс давсан хэвээр байгаа тул хүүгийн түвшин удаан хугацаанд өндөр хэвээр байна.” гэдгийг онцолжээ.

Эх сурвалж: www.imf.com

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“BANK OF AMERICA”-ГИЙН ҮНЭТ ЦААСНЫ БОДИТ БУС АЛДАГДАЛ 131.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЧЭЭ .

НЬЮ-ЙОРК, 10 дугаар сарын 17, Холбооны нөөцийн банк 2023 оны 3 дугаар улиралд 131.6 тэрбум ам.долларын бодит бус алдагдал хүлээсэн нь хоёрдугаар улирлаас өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч энэ нь урт хугацаанд багцын бодит алдагдал хүлээхгүй байх төлөвтэй байна.



2023 оны 3 дугаар сараас хойш бодит бус алдагдал хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байсан. Тухайн үед Цахиурын хөндийн банк өөрийн эзэмшлийн багцаа огцом алдагдалтай зарсан нь түүний уналтыг түргэсгэж, 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн муу салбарын үймээнийг өдөөсөн юм.

Эх сурвалж: www.reuters.com

2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР АНУ-ЫН СУУРЬ ИНФЛЯЦЫН ТҮВШИН 0.3 ХУВИАР ӨСЛӨӨ.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар АНУ-ын суурь инфляцын түвшин 0.3 хувиар өссөн нь сүүлийн хоёр сар дараалан эрчимжсэн үзүүлэлт юм.

АНУ-ын Холбооны Нөөцийн банк инфляцыг хязгаарлахаар бодлогын хүүгээ өндөр түвшинд хадгалахад түлхэц болж байна.

Эдийн засагчдын хувьд инфляцаас илүү тодорхой үзүүлэлт гэж үздэг хүнс, эрчим хүчний үнэ тооцоогүй суурь инфляцын түвшин 0.3 хувиар өссөн бол ерөнхий инфляцын түвшин 0.4 хувиар өсжээ.

Мөн инфляцын үзүүлэлтээс харвал хөдөлмөрийн зах зээл идэвхтэй байсан нь хэрэглэгч талаас эрэлт өндөр байхад нөлөөлж байна. Ингэснээр Холбооны Нөөцийн банканд үнийн өсөлтийн дарамт үргэлжлэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа аж.

АНУ-ын Төв банкны сүүлийн хуралдаанаар энэ онд дахин нэг удаа бодлогын хүүгээ өсгөх боломжтой гэж ихэнх нь гишүүд нь үзэж байсан юм.




Эх сурвалж: www.bloomberg.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

S&P 500 /^GSPC/

4,278.00 -36.60 (-0.85%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


31,259.36 -171.26 (-0.54%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,431.39 -68.27 (-0.91%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,186.18 -128.13 (-0.96%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC_of_Mongolia